



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДАА-2022/73/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр

Утас: 7037-3089

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 7037-3089

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Л.Дамдинжав

Утас: 70376994

Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	102
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4.Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Акт тогтоох.....	18
4.3 Зөвлөмж.....	18
5.Аудитын илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ХОНГОР СУМЫН 11 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Н.ПҮРЭВБААТАР ТАНАА

2022.02.25 № 191
танай _____-ны № _____-т



Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн зөв, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.МӨНХБАЯР

008080167

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	71,291,485.37	70,817,634.82
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө		
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө		
35	БАРАА МАТЕРИАЛ	71,291,485.37	70,817,634.82
35100	Түүхий эд материал	18,925,013.19	15,558,717.64
35110	Тусгай зориулалттай материал	18,829,613.19	15,454,917.64
35130	Эм боох материал	95,400.00	103,800.00
35400	Хангамжийн материал	52,366,472.18	55,258,917.18
35410	Бичиг хэргийн материал	2,304,350.00	1,593,810.00
35420	Аж ахуйн материал	6,839,386.18	5,449,534.18
35450	Барилгын засварын материал	12,471,940.00	14,319,158.00
35460	Хүнсний материал	0.00	903,490.00
35470	Бусад хангамжийн материал	30,750,796.00	32,992,925.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,923,480,725.43	1,857,103,666.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,923,480,725.43	1,857,103,666.19
39200	Биет хөрөнгө	1,869,214,975.74	1,804,332,591.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,800,863,898.00	1,800,863,898.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(74,581,702.68)	(112,034,849.52)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	140,497,054.31	140,497,054.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	(50,360,874.04)	(80,015,720.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,065,689.83	49,676,866.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,665,829.38)	(29,502,953.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,628,740.00	23,628,740.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,652,336.40)	(7,740,755.68)
39217	Ном	17,420,336.10	18,960,312.86
39300	Биет бус хөрөнгө	54,265,749.69	52,771,074.88
39301	Програм хангамж	7,743,936.00	7,743,936.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,968,186.31)	(7,462,861.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	52,490,000.00	52,490,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,994,772,210.80	1,927,921,301.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	23,504,244.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	23,504,244.00	0.00
41300	Өглөг	23,504,244.00	0.00
41360	Бусад өглөг	23,504,244.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	23,504,244.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,971,267,966.80	1,927,921,301.01
51	Засгийн газрын хувь оролцоо	1,971,267,966.80	1,927,921,301.01
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	825,612,346.61	825,612,346.61
51200	Хуримтлагдсан үр дүн	(1,003,385,712.79)	(1,046,732,378.58)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,010,498,555.32)	(1,003,385,712.79)
51220	Тайлант үеийн үр дүн	7,112,842.53	(43,346,665.79)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,149,041,332.98	2,149,041,332.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,994,772,210.80	1,927,921,301.01

BAKERTILLY
"DALAIAN -AUDIT" CO.,Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	777,810,983.87	776,501,230.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90,261,283.87	11,517,153.06
120	Нийтлэг татварын бус орлого	90,261,283.87	11,517,153.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	680,000.00	426,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	426,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	680,000.00	70,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	86,100,856.50	10,851,153.06
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,480,427.37	170,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	687,549,700.00	764,984,077.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	562,353,200.00	584,851,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	562,353,200.00	584,851,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,000.00	4,854,277.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,854,277.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	125,161,500.00	175,278,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	125,161,500.00	175,278,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	770,698,141.34	819,847,895.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	770,698,141.34	819,847,895.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	754,302,736.83	788,312,080.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	465,045,706.00	480,908,494.15
210101	Үндсэн цалин	412,448,303.00	353,591,187.76
210102	Нэмэгдэл	10,997,403.00	94,438,937.39
210104	Урамшуулал	41,600,000.00	32,878,369.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,615,143.49	63,340,119.29
210201	Тэтгэврийн даатгал	38,516,700.00	45,647,823.34
210202	Тэтгэмжийн даатгал	4,915,800.00	4,968,420.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,956,600.00	3,222,076.50
210204	Ажилгүйдлийн даатгал	989,200.00	766,047.43
210205	Эрүүл мэндийн даатгал	11,236,843.49	8,735,751.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,385,444.00	133,350,312.59
210301	Гэрэл, цахилгаан	5,269,850.00	4,846,836.92
210302	Түлш, халаалт	107,823,044.00	127,758,439.00
210303	Цэвэр, бохир ус	6,292,550.00	745,036.67
2104	Хангамж, бараа материалын зардал	11,711,381.15	10,190,532.55
210401	Бичиг хэрэг	2,738,804.00	1,721,762.00
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	787,920.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	886,377.00	394,647.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,604,770.00	931,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,023,930.00	1,549,508.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	410,850.00
210408	Бараа материал акалсны зардал	3,657,500.15	4,394,195.55
2105	Нормативт зардал	7,243,890.00	9,336,370.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	819,500.00	475,400.00

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	6,394,390.00	8,860,970.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,318,895.00	7,501,740.00
210604	Урсгал засвар	27,318,895.00	7,501,740.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,375,000.00	660,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,775,000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	660,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,607,277.19	83,024,512.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	336,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	204,000.00	5,160,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,403,277.19	77,528,212.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,395,404.51	31,535,814.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,127,700.00	15,438,680.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,887,700.00	14,808,680.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	240,000.00	630,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	7,672,249.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	7,672,249.56
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	423,971.00	8,424,885.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	423,971.00	8,424,885.41
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,843,733.51	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,843,733.51	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	7,112,842.53	(43,346,665.79)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	7,112,842.53	(43,346,665.79)

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	825,612,346.61	2,149,041,332.98	(1,010,498,555.32)	1,964,155,124.27
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	825,612,346.61	2,149,041,332.98	(1,010,498,555.32)	1,964,155,124.27
9	Тайлант үеийн үр дүн			7,112,842.53	7,112,842.53
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	825,612,346.61	2,149,041,332.98	(1,003,385,712.79)	1,971,267,966.80
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	825,612,346.61	2,149,041,332.98	(1,003,385,712.79)	1,971,267,966.80
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	825,612,346.61	2,149,041,332.98	(1,003,385,712.79)	1,971,267,966.80
19	Тайлант үеийн үр дүн			(43,346,665.79)	(43,346,665.79)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	825,612,346.61	2,149,041,332.98	(1,046,732,378.58)	1,927,921,301.01

2.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	688,229,700.00	765,480,077.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО		
110	Орлогын албан татвар		
1100	Хувь хүний орлогын албан татвар		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	680,000.00	426,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	680,000.00	426,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	680,000.00	426,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	426,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	680,000.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	687,549,700.00	764,984,077.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	562,353,200.00	584,851,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	562,353,200.00	584,851,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,000.00	4,854,277.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,854,277.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	125,161,500.00	175,278,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	125,161,500.00	175,278,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	686,393,800.00	765,180,077.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	686,393,800.00	765,180,077.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	671,217,705.49	733,260,702.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	466,400,000.00	480,908,494.15
210101	Үндсэн цалин	413,802,597.00	353,591,187.76
210102	Нэмэгдэл	10,997,403.00	94,438,937.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	41,600,000.00	32,878,369.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,260,849.49	63,340,119.29
210201	Тэтгэврийн даатгал	38,516,700.00	45,647,823.34
210202	Тэтгэмжийн даатгал	4,915,800.00	4,968,420.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,956,600.00	3,222,076.50
210204	Ажилгүйдлийн даатгал	989,200.00	766,047.43
210205	Эрүүл мэндийн даатгал	9,882,549.49	8,735,751.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,881,200.00	156,854,556.59
210301	Гэрэл, цахилгаан	5,269,850.00	4,846,836.92
210302	Түлш, халаалт	84,346,000.00	151,214,583.00
210303	Цэвэр, бохир ус	6,265,350.00	793,136.67
2104	Хангамж, бараа материалын зардал	7,262,927.00	4,681,435.00
210401	Бичиг хэрэг	684,900.00	1,001,222.00
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	787,920.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	914,377.00	394,647.00
210404	Ном, хэвлэл	264,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	2,790,770.00	1,382,548.00

	ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,808,880.00	1,115,098.00
2105	Нормативт зардал	7,681,400.00	9,655,199.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	758,400.00	84,800.00
210502	Хоол, хүнс	5,778,000.00	9,380,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,145,000.00	189,499.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,856,329.00	9,998,958.00
210604	Урсгал засвар	28,856,329.00	9,998,958.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,375,000.00	660,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,775,000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	660,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.00	7,161,940.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	366,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дэдлага хийх	3,500,000.00	6,795,640.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,176,094.51	31,919,374.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,908,390.00	15,822,240.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,668,390.00	15,192,240.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	240,000.00	630,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	7,672,249.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	7,672,249.56
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	423,971.00	8,424,885.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	423,971.00	8,424,885.41
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,843,733.51	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,843,733.51	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,835,900.00	300,000.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,835,900.00	300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,835,900.00	300,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,835,900.00	300,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,835,900.00	300,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,835,900.00)	(300,000.00)

BAKERTILLY
"DALAIVAN -AUDIT"CO.,Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAIGAL

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Харьцуулалт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	760,129,800.00	744,458,665.03	15,671,134.97	98%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	760,129,800.00	744,158,665.03	15,971,134.97	98%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	743,282,400.00	728,336,425.03	14,945,974.97	98%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	484,825,100.00	480,908,494.15	3,916,605.85	99%
210101	Үндсэн цалин	353,747,300.00	353,591,187.76	156,112.24	100%
210102	Нэмэгдэл	94,472,100.00	94,438,937.39	33,162.61	100%
210104	Урамшуулал	36,605,700.00	32,878,369.00	3,727,331.00	90%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,285,700.00	63,340,119.29	945,580.71	99%
210201	Тэтгэврийн даатгал	45,014,000.00	45,647,823.34	-633,823.34	101%
210202	Тэтгэмжийн даатгал	4,818,100.00	4,968,420.78	-150,320.78	103%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,853,700.00	3,222,076.50	631,623.50	84%
210204	Ажилгүйдлийн даатгал	963,600.00	766,047.43	197,552.57	79%
210205	Эрүүл мэндийн даатгал	9,636,300.00	8,735,751.24	900,548.76	91%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,278,400.00	156,854,556.59	8,423,843.41	95%
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	4,846,836.92	1,153,163.08	81%
210302	Түлш, халаалт	151,378,400.00	151,214,583.00	163,817.00	100%
210303	Цэвэр, бохир ус	7,900,000.00	793,136.67	7,106,863.33	10%
210304	Байрны түрээс	0	0	0.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	4,764,700.00	4,057,158.00	707,542.00	91%
210401	Бичиг хэрэг	650,000.00	769,993.00	-119,993.00	118%
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	787,920.00	12,080.00	98%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,030,000.00	394,647.00	635,353.00	38%
210404	Ном, хэвлэл	300,000.00		300,000.00	100%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	869,500.00	989,500.00	-120,000.00	114%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,115,200.00	1,115,098.00	102.00	100%
2105	Нормативт зардал	10,482,200.00	9,655,199.00	827,001.00	92%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,800.00	84,800.00	0.00	100%
210502	Хоол, хүнс	10,207,900.00	9,380,900.00	827,000.00	92%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	189,500.00	189,499.00	1.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	9,998,958.00	1,042.00	100%
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,998,958.00	1,042.00	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	660,000.00	660,000.00	0.00	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	660,000.00	660,000.00	0.00	100%

BAKERTILLY
"DALAIVAN-AUDIT" CO., Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,986,300.00	2,861,940.00	124,360.00	96%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	486,300.00	366,300.00	120,000.00	75%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,495,640.00	4,360.00	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,847,400.00	15,822,240.00	1,025,160.00	94%
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,847,400.00	15,822,240.00	1,025,160.00	94%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,147,400.00	15,192,240.00	955,160.00	94%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	630,000.00	70,000.00	90%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		300,000.00	-300,000.00	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	760,129,800.00	744,458,665.03	15,671,134.97	98%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	584,851,400.00	577,179,150.44	7,672,249.56	99%
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0	0.00	
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	584,851,400.00	577,179,150.44	7,672,249.56	99%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	175,278,400.00	166,853,514.59	8,424,885.41	95%
320001	Орон нутгийн төсвөөс	175,278,400.00	166,853,514.59	8,424,885.41	95%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	426,000.00	-426,000.00	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	426,000.00	-426,000.00	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100%
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41	40	1.00	100%
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	31	30	1.00	100%
620003	Үйлчлэх ажилтан	9	9	0.00	100%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	274	274	0.00	100%
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	274	274	0.00	100%
630001	Төрийн өмчит ЕБС	274	274	0.00	100%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)				
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)				

2.6 НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,854,277.00	(4,854,277.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,854,277.00	(4,854,277.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,854,277.00	(4,854,277.00)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил			-
210101	Үндсэн цалин			-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл			-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал			-
2104	Хангамж, бараа материалын зардал		554,277.00	(554,277.00)
210401	Бичиг хэрэг		161,229.00	(161,229.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		393,048.00	(393,048.00)
2105	Нормативт зардал			-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал			-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		4,300,000.00	(4,300,000.00)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4,300,000.00	(4,300,000.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ			-
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг			-
2132	Бусад урсгал шилжүүлэг			-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			-
2200	Дотоод эх үүсвэрээр			-
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		4,854,277.00	(4,854,277.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		4,854,277.00	(4,854,277.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,854,277.00	(4,854,277.00)
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			-

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын Ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Л.Дамдинжав, аудиторын туслах Ж.Сайнбилэг нар гүйцэтгэж, хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Ерөнхий боловсролын 11 дүгээр сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар-т 2022 оны 01 дүгээр сарын 10-ний өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хонгор сумын Ерөнхий боловсролын 11 дүгээр сургууль нь “Шударга, ёс суртахуунтай нийгэм, сүйрэлгүй байгаль орчин, хүчирхэг эдийн засаг нь тогтвортой хөгжлийн үндэс болохыг ухаарсан иргэн болгон төлөвшүүлж, аймаг улсын хэмжээний жишиг эко сургууль болох” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын Ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 399,028.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,990.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,793.0 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Хонгор сумын Ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 66,850.9 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Бараа материал	71,291.5	70,817.6	(473.9)
Үндсэн хөрөнгө	1,923,480.7	1,857,103.7	(66,377.0)
Нийт хөрөнгө	1,994,772.2	1,927,921.3	(66,850.9)
Өр төлбөр	23,504.2		(23,504.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,971,268.0	1,927,921.3	(43,346.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,994,772.2	1,927,921.3	(66,850.9)

Бараа материал дансны үлдэгдэл 473.9 мянган төгрөгөөр буурсан нь Хонгор сумын тамгын газраас 170.0 мянган халуун хэмжигчийг үнэ төлбөргүй хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 40,641.2 мянган төгрөгийн бараа материал бэлтгэсэн, сургуулийн захирлын 2021 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн А/14 тоот тушаалаар 4,394.2 мянган төгрөгийн бараа материал акталж данснаас хассан, 36,890.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 11,151.1 мянган төгрөгөөр өссөн нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 1,240.0 мянган төгрөгийн ном, 611.2 мянган төгрөгийн ширээ сандал, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 9,000.0 мянган төгрөгийн вакумыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, төсвийн хөрөнгөөр 300.0 мянган төгрөгийн ном худалдан авсан нь нөлөөлжээ.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэлд тайлант онд өөрчлөлт гараагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,927,921.3 мянган төгрөг болж 43,346.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

Хонгор сумын Ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 1,309.7 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого буурсан нь голлон нөлөөлжээ.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 49,149.7 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар нь өссөн нь түлш халаалтын зардал өссөнөөс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 837,669.2 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 760,129.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 584,851.4 мянган төгрөгийг улсын төсвөөс *Итүсгай зориулалтын шилжүүлгээр*, 175,278.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 584,851.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 175,278.4 мянган төгрөгийн, түрээсийн орлого 426.0 мянган төгрөгийн, цахим тендерийн орлого 70.0 мянган төгрөг буюу нийт 760,625.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 744,458.7 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 16,097.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 744,458.7 мянган төгрөг буюу 97.9 хувьтай тайлагнагдсан нь цалин, НДШ-ийн зардал 7,644.0 мянган төгрөгөөр, байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 8,423.8 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСШУЯ-с "Хамтдаа хөгжье" төсөл хөтөлбөрийн 4,300.0 мянган төгрөгийн, ариутгал, халдваргүйжүүлэлт 393.0 мянган төгрөгийн, шалгалтын бичиг хэргийн материалд 161.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан "Түр журам журам батлах тухай" тушаалын хоёрдугаар хавсралт "Короновируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр

журам"-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

2. Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь "0" үлдэгдэлтэй болсон 64,595.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 50 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн 49 дэх "... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд "0" үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

3.8 Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь 147 мэдээллийг бүрэн оруулсан, 1 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

1. Хонгор сумын ерөнхий боловсролын 11 дүгээр сургуульд 760,129.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 744,528.7 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 2.0 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: ".....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн

хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1,138.4 мянган төгрөгийн 1 акт, 23,504.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,500.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,320.0 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 58.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 акт тогтоож, 122.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд тендерийн орлого 70.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй, бараа материалын тайланд 1,250.0 мянган төгрөгийн багажийг 2 дахин орлогод бүртгэснийг залрууллаа.

4.2 Акт тогтоох

1. Тушаал шийдвэргүйгээр багш нарт 58.4 мянган төгрөгийн кабинетын нэмэгдэл хөлс олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3, 6.4.5, 6.4.7-д гэсэн заалтуудыг зөрчсөн байгаа тул холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

2. Цалин хөлсний мэдээлэлтэй холбоотой

1.2.1 **Илрүүлэлт** Тооцооллын алдаанаас амралтын цалингаас 122.0 мянган төгрөгийн татвар, шимтгэл суутгаагүй олгосон нь татвар, НДШ-ийн өр үүсэж болзошгүй байна.

1.2.2 **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчиж байгаа тул 2022 оны 1-р улиралд багтаан холбогдох байгууллагуудтай дахин тооцоо нийлж, тулган баталгаажуулах.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/											
д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хонгор сумын 11 дүгээр сургууль	5	1,500.4	2	1,320.0	1	58.4			2	122.0

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.